



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/665

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрлийн
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт орших "Бор чулуут" нэртэй 36.63 гектар талбай бүхий "Эм Жэй Эс Гоулд Майнинг" ХХК-ийн XV-23000060 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг хоёр жилээр сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан тухай ашигт малтмал, газрын тосны болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Мөнх-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Б.Сүнгээ)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ